

ТӨВ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧ

АУДИТЫН КОД: ТӨА-2022/178/НА-СТА-ТШЗ

ТӨВ АЙМГИЙН СЭРГЭЛЭН СУМЫН ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВИЙН 2021 ОНЫ
САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН САНХҮҮГИЙН
ТАЙЛАНГИЙН АУДИТ

Зуунмод 2022 он



Аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал

Утас: 70272582 Цахим хаяг: khishigjargalts@audit.gov.mn

Аудитын менежер О.Амаржаргал

Утас: 70273463 Цахим хаяг: amarjargalo@audit.gov.mn

Ахлах аудитор Т.Майцэцэг

Утас: 70273204 Цахим хаяг: maitsetsegt@audit.gov.mn

Аудитыг гэрээгээр гүйцэтгэгч: Гэрэлтэх бүртгэл Аудит ХХК

Утас: 99884842 Цахим хаяг: gereltekhburtgelaudit02@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу. Цахим хаяг: www.audit.mn

Агуулга

Товчилсон үгийн жагсаалт.....	3
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл.....	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан.....	6
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	7
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	8
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	9
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	11
3. Аудитын тайлан.....	12
3.1 Ерөнхий зүйл.....	12
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	12
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....	12
3.4 Материаллаг байдал.....	13
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга.....	13
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	15
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг	15
3.8 Аудитын гол асуудал	16
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	16
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт.....	16
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	16
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал	17
4. Аудитын илрүүлэлт	17
4.1 Төлбөрийн акт	17
4.2 Албан шаардлага.....	17
4.3 Зөвлөмж.....	18

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
МУЕА	Монгол Улсын Ерөнхий аудитор
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ТБОНӨТХ	Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
ТШЗ	Төсвийн шууд захирагч
ХХОАТ	Хувь хүний орлогын албан татвар
МУЗГ	Монгол Улсын Засгийн газар



**ТӨВ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

41100, Төв аймаг, Зуунмод сум
Утас: 70272582, Цахим шуудан: tuv@audit.gov.mn

2022.02.25 № 01/158
танай _____-ны № _____-т

ТӨВ АЙМГИЙН СЭРГЭЛЭН СУМЫН
ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВИЙН
ДАРГА Х.АРИУН-ЭРДЭНЭ ТАНАА

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Төв аймгийн Сэргэлэн сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Аудитын гол асуудалд дурдсан алдаа, зөрчлийн үр нөлөөг эс тооцвол Төв аймгийн Сэргэлэн сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Аудитын гол асуудал

Аудитын захидалд дурдсан аудитаар илэрсэн орлогын данстай холбоотой 12,890.4 мянган төгрөгийн, авлага өглөгтэй холбоотой 624.6 мянган төгрөгийн, нягтлан бодох бүртгэлийн болон татварын хуулийн хэрэгжилттэй холбоотой 5,110.5 мянган төгрөгийн нийт 18,625.5 мянган төгрөгийн эрсдэлтэй асуудлууд нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, татварын хуулийн холбогдох заалт, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарттай нийцэхгүй, “эрх ба үүрэг” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.ХИШИГЖАРГАЛ

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>50,457,198.26</u>	<u>105,638,186.24</u>
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	-	5,644,065.40
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	-	5,644,065.40
3121	Төгрөг	-	-
31211	Төрийн сангийн харилцах	-	5,644,065.40
31213	Арилжааны банк дахь харилцах	-	-
33	АВЛАГА	332,012.33	25,412,612.33
335	Бусад авлага	332,012.33	25,412,612.33
3351	Байгууллагаас авах авлага	128,252.33	25,208,852.33
3352	Хувь хүмүүсээс авах авлага	203,760.00	203,760.00
35	БАРАА МАТЕРИАЛ	50,125,185.93	74,581,508.51
351	Түүхий эд материал	23,422,759.10	42,880,590.96
35110	Тусгай зориулалттай материал	8,416,693.35	18,106,011.05
35130	Эм боох материал	15,006,065.75	24,774,579.91
354	Хангамжийн материал	26,702,426.83	31,700,917.55
35410	Бичиг хэргийн материал	217,300.00	320,400.00
35420	Аж ахуйн материал	20,087,400.00	28,810,050.00
35430	Сэлбэг хэрэгсэл	38,500.00	
35440	Түлш, шатах тослох материал	3,848,820.13	188,838.85
35460	Хүнсний материал	2,179,669.70	2,050,891.70
35470	Бусад хангамжийн материал	330,737.00	330,737.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>255,627,626.84</u>	<u>326,534,854.10</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	255,627,626.84	326,534,854.10
392	Биет хөрөнгө	225,601,626.84	296,508,854.10
39201	Барилга, байгууламж, орон сууц	194,942,920.00	233,142,920.13
39202	Хуримтлагдсан элэгдэл	(22,728,377.84)	(30,777,585.56)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	93,604,800.00	93,604,800.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(70,257,716.95)	(83,452,716.87)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	78,085,516.91	134,032,279.87
39206	Хуримтлагдсан элэгдэл	(58,366,019.07)	(63,213,260.59)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	16,819,753.00	21,702,753.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(7,422,079.21)	(9,453,165.88)
39217	Ном	922,830.00	922,830.00
393	Биет бус хөрөнгө	30,026,000.00	30,026,000.00
39301	Програм хангамж	400,000.00	400,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	30,026,000.00	30,026,000.00
39304	Хасагдуулга	(400,000.00)	(400,000.00)
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>306,084,825.10</u>	<u>432,173,040.34</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	<u>292,600.00</u>	<u>292,600.00</u>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	292,600.00	292,600.00
413	Өглөг	-	-
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	-	-
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	-	-
4136	Бусад өглөг	292,600.00	292,600.00
41361	Байгууллагад төлөх өглөг	1,500.00	1,500.00
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	291,100.00	291,100.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>305,792,225.23</u>	<u>431,880,440.34</u>

Төв аймгийн Сэргэлэн сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

51	Засгийн газрын хувь оролцоо	305,792,225.23	431,880,440.34
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	195,310,308.92	195,310,308.92
51101	Өмч: - төрийн	195,310,308.92	195,310,308.92
512	Хуримтлагдсан үр дүн	110,481,916.31	236,570,131.42
51210	Өмнөх үеийн үр дүн	83,721,266.90	83,721,266.90
51220	Тайлант үеийн үр дүн		126,088,215.11
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	26,760,649.41	26,760,649.41
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>306,084,825.23</u>	<u>432,173,040.34</u>

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	379,163,700.64	738,369,293.15
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	21,874,642.64	214,437,488.15
120	Нийтлэг татварын бус орлого	21,874,642.64	214,437,488.15
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	21,874,642.64	214,437,488.15
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан-Бараа материал	21,874,642.64	214,437,488.15
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	49,042,158.00	184,285,505.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	308,246,900.00	339,646,300.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	11,754,066.00	147,436,555.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	2,761,000.00	-
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	8,993,066.00	134,546,205.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	12,890,350.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	17,021,400.00	17,021,400.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	17,021,400.00	17,021,400.00
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	20,266,692.00	19,827,550.00
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	20,266,692.00	19,827,550.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	378,743,845.62	612,281,078.04
21	УРСГАЛ ЗАРДАЛ	378,743,845.62	612,281,078.04
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	374,525,482.08	612,251,929.84
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	250,335,884.06	273,791,316.95
210101	Үндсэн цалин	250,335,884.06	273,705,445.00
210102	Нэмэгдэл		85,871.95
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	32,008,276.66	38,863,792.65
210201	Тэтгэврийн даатгал	21,991,558.66	27,945,505.65
210202	Тэтгэмжийн даатгал	2,509,912.00	2,729,572.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,007,931.00	2,183,656.00
210204	Ажилгүйдлийн даатгал	499,898.00	545,914.00
210205	Эрүүл мэндийн даатгал	4,998,977.00	5,459,145.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	13,547,593.00	19,452,233.08

Төв аймгийн Сэргэлэн сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210301	Гэрэл, цахилгаан	3,867,213.00	4,233,053.00
210302	Түлш, халаалт	8,585,830.00	13,852,980.08
210303	Цэвэр, бохир ус	1,094,550.00	1,366,200.00
2104	Хангамж, бараа материалын зардал	13,094,739.00	18,374,984.00
210401	Бичиг хэрэг	1,872,050.00	1,285,200.00
210402	Тээвэр, шатахуун	10,652,689.00	16,454,784.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	450,000.00	635,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	120,000.00	
2105	Нормативт зардал	24,598,131.06	127,403,793.38
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	17,566,197.06	116,140,515.38
210502	Хоол, хүнс	7,031,934.00	11,263,278.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	385,717.00	-
210601	Багаж, техник, хэрэгсэл	114,000.00	
210604	Урсгал засвар	271,717.00	
2107	Томилолт, зочны зардал	264,000.00	12,000.00
210702	Дотоод албан томилолт	264,000.00	12,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	574,000.00	-
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	324,000.00	
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	250,000.00	
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	39,717,141.30	134,353,809.78
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	9,239,234.00	102,170,853.95
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	30,477,907.30	32,182,955.83
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	4,218,363.54	29,148.20
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	4,218,363.54	29,148.20
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	4,218,363.54	29,148.20
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	419,855.02	126,088,215.11
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	419,855.02	126,088,215.11

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	195,310,308.92	26,760,649.41	83,301,411.88	305,372,370.21
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	195,310,308.92	26,760,649.41	83,301,411.88	305,372,370.21
C07	Тайлант үеийн үр дүн	-	-	419,855.02	419,855.02
C08	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	195,310,308.92	26,760,649.41	83,721,266.90	305,792,225.23
D01	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	195,310,308.92	26,760,649.41	83,721,266.90	305,792,225.23
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	195,310,308.92	26,760,649.41	83,721,266.90	305,792,225.23
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	126,088,215.11	126,088,215.11

Төв аймгийн Сэргэлэн сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

D09	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	195,310,308.92	26,760,649.41	209,809,482.01	431,880,440.34
-----	---------------------------------------	----------------	---------------	----------------	----------------

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	357,289,058.00	498,851,205.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	357,289,058.00	498,851,205.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	308,246,900.00	339,646,300.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	11,754,066.00	122,355,955.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	2,761,000.00	-
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	8,993,066.00	109,465,605.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	12,890,350.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	17,021,400.00	17,021,400.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	17,021,400.00	17,021,400.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	20,266,692.00	19,827,550.00
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	20,266,692.00	19,827,550.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	348,829,158.00	488,344,339.40
21	УРСГАЛ ЗАРДАЛ	348,829,158.00	488,344,339.40
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	344,610,794.46	487,307,191.40
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	250,601,625.00	267,908,908.60
210101	Үндсэн цалин	174,098,419.00	152,969,669.73
210102	Нэмэгдэл	64,450,306.00	89,487,802.05
210103	Унаа хоолны хөнгөлөлт		4,338,000.00
210104	Урамшуулал	12,052,900.00	21,113,436.82
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	31,742,535.72	36,610,000.00
210201	Тэтгэврийн даатгал	23,319,803.88	25,703,200.00
210202	Тэтгэмжийн даатгал	2,518,577.21	2,726,600.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,014,841.78	2,181,400.00
210204	Ажилгүйдлийн даатгал	503,735.43	545,400.00
210205	Эрүүл мэндийн даатгал	3,385,577.42	5,453,400.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	15,328,583.00	15,792,251.80
210301	Гэрэл, цахилгаан	3,867,213.00	4,233,053.00
210302	Түлш, халаалт	10,366,820.00	10,192,998.80
210303	Цэвэр, бохир ус	1,094,550.00	1,366,200.00
2104	Хангамж, бараа материалын зардал	14,052,439.00	18,909,784.00
210401	Бичиг хэрэг	999,750.00	1,000,000.00
210402	Тээвэр, шатахуун	10,652,689.00	15,654,784.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	900,000.00	755,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,500,000.00	1,500,000.00
2105	Нормативт зардал	19,586,336.74	19,389,189.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	12,087,016.74	11,889,189.00
210502	Хоол, хүнс	7,499,320.00	7,500,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	6,868,151.00	5,900,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	1,635,000.00	1,600,000.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	4,100,000.00	3,100,000.00

Төв аймгийн Сэргэлэн сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210604	Урсгал засвар	1,133,151.00	1,200,000.00
2107	Томилолт, зочны зардал	264,000.00	12,000.00
210702	Дотоод албан томилолт	264,000.00	12,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,574,000.00	-
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,000,000.00	
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	324,000.00	
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	250,000.00	-
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	4,593,124.00	122,785,058.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	4,593,124.00	122,785,058.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	4,218,363.54	1,037,148.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	-	-
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал		1,008,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг		
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	4,218,363.54	29,148.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<u>8,459,900.00</u>	<u>10,506,865.60</u>
	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	≡	≡
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	8,459,900.00	4,862,800.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	8,459,900.00	4,862,800.00
2200	Дотоод эх үүсвэрээр	8,459,900.00	4,862,800.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	8,459,900.00	4,862,800.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	<u>(8,459,900.00)</u>	<u>(4,862,800.00)</u>
	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	≡	≡
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	-	5,644,065.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	5,644,065.00

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны		Зөрүү	Хувь
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл		
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	377,067,600.00	370,822,036.40	6,245,563.60	98.34
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	377,067,600.00	370,822,036.40	6,245,563.60	98.34
21	УРСГАЛ ЗАРДАЛ	377,067,600.00	370,822,036.40	6,245,563.60	98.34
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	377,067,600.00	370,822,036.40	6,245,563.60	98.34
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	272,667,000.00	267,908,908.60	4,758,091.40	98.25

Төв аймгийн Сэргэлэн сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210101	Үндсэн цалин	153,217,700.00	152,969,669.73	248,030.27	99.84
210102	Нэмэгдэл	91,930,600.00	89,487,802.05	2,442,797.95	97.34
210103	Унаа хоолны хөнгөлөлт	4,536,000.00	4,338,000.00	198,000.00	95.63
210104	Урамшуулал	22,982,700.00	21,113,436.82	1,869,263.18	91.87
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	36,810,000.00	36,610,000.00	200,000.00	99.46
210201	Тэтгэврийн даатгал	25,903,200.00	25,703,200.00	200,000.00	99.23
210202	Тэтгэмжийн даатгал	2,726,600.00	2,726,600.00	-	100.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,181,400.00	2,181,400.00	-	100.00
210204	Ажилгүйдлийн даатгал	545,400.00	545,400.00	-	100.00
210205	Эрүүл мэндийн даатгал	5,453,400.00	5,453,400.00	-	100.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	15,821,400.00	15,792,251.80	29,148.20	99.82
210301	Гэрэл, цахилгаан	5,464,400.00	4,233,053.00	1,231,347.00	77.47
210302	Түлш, халаалт	10,000,000.00	10,192,998.80	(192,998.80)	101.93
210303	Цэвэр, бохир ус	357,000.00	1,366,200.00	(1,009,200.00)	382.69
2104	Хангамж, бараа материалын зардал	19,180,000.00	18,909,784.00	270,216.00	98.59
210401	Бичиг хэрэг	1,000,000.00	1,000,000.00	-	100.00
210402	Тээвэр, шатахуун	15,780,000.00	15,654,784.00	125,216.00	99.21
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	900,000.00	755,000.00	145,000.00	83.89
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,500,000.00	1,500,000.00	-	100.00
2105	Нормативт зардал	19,389,200.00	19,389,189.00	11.00	100.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	11,889,200.00	11,889,189.00	11.00	100.00
210502	Хоол, хүнс	7,500,000.00	7,500,000.00	-	100.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	5,900,000.00	5,900,000.00	-	100.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	1,600,000.00	1,600,000.00	-	100.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	3,100,000.00	3,100,000.00	-	100.00
210604	Урсгал засвар	1,200,000.00	1,200,000.00	-	100.00
2107	Томиллолт, зочны зардал	1,000,000.00	12,000.00	988,000.00	1.20
210702	Дотоод албан томилолт	1,000,000.00	12,000.00	988,000.00	1.20

Төв аймгийн Сэргэлэн сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

2109	Бараа үйлчилгээний бусад зардал	6,300,000.00	6,299,903.00	97.00	100.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	6,300,000.00	6,299,903.00	97.00	100.00
1	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	377,067,600.00	376,495,250.00	572,350.00	99.85
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	339,646,300.00	339,646,300.00	-	100.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	339,646,300.00	339,646,300.00	-	100.00
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	17,021,400.00	17,021,400.00	-	100.00
132001	Орон нутгийн төсвөөс	17,021,400.00	17,021,400.00	-	100.00
1340	НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	20,399,900.00	19,827,550.00	572,350.00	97.19
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	20,399,900.00	19,827,550.00	572,350.00	97.19
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-	-	-
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	5,644,065.40	(5,644,065.40)	-

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны
		Гүйцэтгэл
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	122,355,955.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	122,355,955.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	121,347,955.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	121,347,955.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	121,347,955.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,008,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,008,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,008,000.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	122,355,955.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	122,355,955.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	109,465,605.00
	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	12,890,350.00

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Төв аймгийн Сэргэлэн сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд хөрөнгийн ашиглалт, цалингийн тооцоолол, татварын хуулийн хэрэгжилт, шилэн дансны хэрэгжилтэй холбоотой өгсөн зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг Гэрэлтэх бүртгэл Аудит ХХК-ийн ахлах аудитор С.Дашдэндэв, аудитор Д.Галт-Эрдэнэ, аудиторын туслах Э.Алтангэрэл, аудиторын туслах Ч.Мөнхбаясгалан нар гүйцэтгэж, чанарын хяналтыг чанарын хяналтын менежер Д.Батмөнх, захирал А.Сарангэрэл, Төв аймаг дахь Төрийн аудитын газрын аудитын менежер О.Амаржаргал, дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал нар тус тус хэрэгжүүлсэн.

Төв аймгийн Сэргэлэн сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Гэрэлтэх бүртгэл Аудит ХХК-д 2022 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 11/02 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Төв аймгийн Сэргэлэн сумын Эрүүл мэндийн төв нь эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээг тэгш, хүртээмжтэй, чанартай үзүүлэх үйл ажиллагаа явуулдаг Эрүүл мэндийн яамны харьяа байгууллага юм.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Төв аймгийн Сэргэлэн сумын Эрүүл мэндийн төв нь 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зарлагыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл бага гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 2.0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зарлагаас 2.0 хувиар буюу 7,574.9 мянган төгрөгөөр тогтоож, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувиар буюу 5,681.2 мянган төгрөгөөр тогтоосон.

Төлөвлөх үе шатанд тооцсон ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Төв аймгийн Сэргэлэн сумын Эрүүл мэндийн төв нь 2021 оны санхүүгийн үйл ажиллагаандаа Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Шилэн дансны тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулиудыг мөрдлөг болгон ажиллаж 2021 оны 01 дүгээр сарын 01-ээс 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр тасалбар болгон санхүүгийн тайлант хугацааны үйл ажиллагаа, санхүүгийн үр дүнг тусган тайлагнасан байна.

Санхүүгийн алба нь “Payroll”, “Acolous” санхүүгийн программыг ашиглаж байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	-	5,644.1	5,644.1
Авлага	332.0	25,412.6	25,080.6
Урьдчилгаа	-	-	-
Бараа материал	50,125.2	74,581.5	24,456.3
Үндсэн хөрөнгө	255,627.6	326,534.9	70,907.3
Нийт хөрөнгө	306,084.8	432,173.1	126,088.3
Өр төлбөр	292.6	292.6	-
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	305,792.1	431,880.4	126,088.3
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	306,084.8	432,173.1	126,088.3

Авлага дансны үлдэгдэл 25,412.6 мянган төгрөг болж, 25,080.6 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газраас санхүүжүүлсэн Ковид 19-тэй холбоотой Эрүүл мэндийн даатгалын санхүүжилтийг авлагаар тусгасантай холбоотой байна.

Авлагын дансны үлдэгдэлд Эрүүл мэндийн даатгалын санхүүжилтийн авлага 25,080.6 мянган төгрөг, Тун эрдэнэ фармаас авах авлага 50.8 мянган төгрөг, Иргэн Бямбацогтоос авах 112.9 мянган төгрөгийн, Иргэн Цэмбээгээс авах 87.3 мянган төгрөгийн, Астра фарм ХХК-аас авах 0.4 мянган төгрөгийн, Иргэн Даваасүрэнгээс авах 3.5 мянган төгрөгийн, Чоногол ХХК-аас авах 77.0 мянган төгрөгийн нийт 25,412.6 мянган төгрөгийн авлагатай байна. Он дамжсан 2 байгууллагатай холбоотой 128.3 мянган төгрөгийн, 3 иргэнтэй холбоотой 203.8 мянган төгрөгийн нийт 332.0 мянган төгрөгийн авлагатай байна.

Авлагын дансны үлдэгдэлд тусгагдсан Эрүүл мэндийн даатгалын санхүүжилтийн авлага 25,080.6 мянган төгрөгийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулсан.

Бараа материалын дансны үлдэгдэл 74,581.5 мянган төгрөг болж, 24,456.3 мянган төгрөгөөр өссөн нь Ковид 19 цар тахалтай холбоотой хандиваар ирсэн хөрөнгүүд нэмэгдсэнээс шалтгаалсан байна. Үүнд:

Бараа материалын данс Эрүүл мэндийн газраас 105,654.1 мянган төгрөгийн Ковид 19 цар тахалтай холбоотой вакцин, эмнэлгийн хэрэгсэл, оношлуур, хамгаалах хувцас хэрэгсэл, Цэцүүх трейд ХХК-аас 1,188.0 мянган төгрөгийн нэг удаагийн маск, автомат автомакс, бактерцидний ламп, Медикал ресурс ХХК-аас 3,405.0 мянган төгрөгийн эмнэлгийн бага үнэтэй тоног төхөөрөмж, Монос фарм трейд ХХК-аас 5,463.0 мянган төгрөгийн Зорилтот бүлгийн 90 иргэний дархлаажуулалтын багц, Гүн зэгстэй ХХК-аас 500.0 мянган төгрөгийн шатахуун, нийт 116,210.1 мянган төгрөгийн хөрөнгөөр нэмэгджээ.

Бараа материалын данс акталж устгасан аж ахуйн материал, эмийн 5,321.6 мянган төгрөгөөр хасагджээ.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 326,534.9 мянган төгрөг болж, 70,907.3 мянган төгрөгөөр өссөн. Үндсэн хөрөнгийн данс Ковид 19 цар тахалтай холбоотой хандиваар ирсэн хөрөнгүүдээр нэмэгдсэн байна. Үүнд:

Эрүүл мэндийн газраас 19,845.2 мянган төгрөгийн дипиврилятор төхөөрөмж, өвчтөний монитор, мөсөн ханатай хөргөгч, компьютер суурин, хүчилтөрөгч өтгөрүүлэгч аппарат, Цэцүүх трейд ХХК-аас 2,400.0 мянган төгрөгийн хүчилтөрөгч өтгөрүүлэгч аппарат, Медикал ресурс ХХК-аас 30,282.2 мянган төгрөгийн шарлалт хэмжигч багаж, нярайн шарлалтын аппарат, шарлагын аппарат, цусны шинжилгээний аппарат, өвчтөний ор, Нью семетри ХХК-аас 38,200.0 мянган төгрөгийн сайжруулалт хийсэн Эрүүл мэндийн төвийн моргийн байшин, 7,500.00 мянган төгрөгийн цогцос хадгалах шүүгээ, нийт 98,227.4 мянган төгрөгийн хөрөнгө хандивласан байна.

Үндсэн хөрөнгийн данс Сумын иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2021 оны 12 дугаар сарын 22-ны өдрийн 69 дугаар тогтоолоор 3 нэр төрлийн 4,060.4 мянган төгрөгийн анхны өртгөө хуримтлагдсан элэгдлээрээ нөхсөн ашиглах боломжгүй хөрөнгийг акталж устгаснаар хасагджээ.

Өр төлбөр дансны үлдэгдэлд иргэн Батхишигт өгөх 125.0 мянган төгрөг, Мэдээллийн гарц ХХК-д өгөх 1.5 мянган төгрөг, Иргэн Оюунцэцэгт өгөх 165.6 мянган төгрөг, Иргэн Алтантулгад өгөх 0.5 мянган төгрөгийн, нийт 292.6 мянган төгрөгийн он дамжсан өр төлбөртэй байна.

Санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 359,205.6 мянган төгрөгөөр өссөн. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан үнэ төлбөргүй хүлээн авсан орлого байна. Энэ нь үндсэн хөрөнгийн дансанд хандиваар ирсэн 116,210.1 мянган төгрөгийн, бараа материалын дансанд хандиваар ирсэн 98,227.4 мянган төгрөгийн, нийт 214,437.5 мянган төгрөгийн хөрөнгөөр нэмэгдсэн байна.

Ковид 19-тэй холбоотой түргэвчилсэн оношилгоо шинжилгээний төлбөрийн орлого 12,890.4 мянган төгрөг, Эрүүл мэндийн даатгалын сангаас тусламж үйлчилгээний 19,827.6 мянган төгрөг, нийт 32,718.0 мянган төгрөгийн санхүүжилтийг үндсэн үйл ажиллагааны орлогоор бүртгэсэн байна.

Санхүүгийн үр дүнгийн тайлангаар үйл ажиллагааны зардал өмнөх оноос 237,726.5 мянган төгрөгөөр өссөн. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан эмийн зардал, бусад бараа үйлчилгээний зардал байна. Энэ нь Ковид 19-тэй холбоотой эм бэлдмэл, нэг хэрэглэдэг хамгаалалтын хувцасны зарцуулалт нэмэгдсэнтэй холбоотой байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллага нь 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 439,800.0 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 439,800.0 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 62,732.4 мянган төгрөгөөр бууруулж, 377,067.6 мянган төгрөгөөр баталсан байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 3 хөтөлбөрийн 34 арга хэмжээг санхүүжүүлэхээр 377,067.6 мянган төгрөгийн төсөв баталснаас 339,646.3 мянган төгрөгийг улсын төсвөөс, 17,021.4 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс, 20,339.9 мянган төгрөгийг эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 339,646.3 мянган төгрөгийн санхүүжилт авч, орон нутгийн төсвөөс 17,021.4 мянган төгрөг, эрүүл мэндийн даатгалын сангаас 19,827.6 мянган төгрөг орлого бүрдүүлж нийт 376,495.3 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, урсгал үйл ажиллагаанд 370,822.0 мянган төгрөгийг зарцуулж, 29.1 мянган төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлсэн байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансанд Эрүүл мэндийн даатгалын Ерөнхий газраас Ковид-19 өөр хэвтэн эмчлүүлсэн, гэрийн тусгаарлалтад хамрагдсан, дархлаажуулалтад хамрагдсан өвчтөнүүдийн эмчилгээ үйлчилгээний төлбөрийн 122,355.9 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлжээ.

Нэмэлт санхүүжилтийн дансанд нийт 122,355.9 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлж, урсгал зардалд зарцуулжээ.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Байгууллагын удирдлага нь санхүүгийн тайлангаа бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг ашигласан байна. Цаашид тус байгууллагын талаар чиг үүрэг нь өөрчлөгдөж татан буугдах, нэгдэх асуудал гараагүй тул байгууллагын тасралтгүй байдлын талаар нөхцөл үүсээгүй гэж үзсэн болно.

3.8 Аудитын гол асуудал

Санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 359,205.6 мянган төгрөгөөр өссөн. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан үнэ төлбөргүй хүлээн авсан орлого байна. Энэ нь үндсэн хөрөнгийн дансанд хандиваар ирсэн 116,210.1 мянган төгрөгийн, бараа материалын дансанд хандиваар ирсэн 98,227.4 мянган төгрөгийн, нийт 214,437.5 мянган төгрөгийн хөрөнгөөр нэмэгдсэн байна.

Санхүүгийн үр дүнгийн тайлангаар үйл ажиллагааны зардал өмнөх оноос 237,726.5 мянган төгрөгөөр өссөн. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан эмийн зардал, бусад бараа үйлчилгээний зардал байна. Энэ нь Ковид 19-тэй холбоотой эм бэлдмэл, нэг хэрэглэдэг хамгаалалтын хувцасны зарцуулалт нэмэгдсэнтэй холбоотой байна.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан 10 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Төв аймгийн Сэргэлэн сумын Эрүүл мэндийн төв нь 2021 онд нийт 444,467.5 мянган төгрөгийн 36 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас 352,674.1 мянган төгрөгийн 23 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн зөрчилтэй байна.

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй байна гэж дүгнэлээ.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 270.7 мянган төгрөгийн 3 алдаа зөрчлийг 100 хувь хэрэгжүүлсэн байна.

Хүснэгт 3. Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт:

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Зөрүү		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Зөвлөмж	3	270.7	3	270.7	-	-	100
Нийт дүн	3	270.7	3	270.7	-	-	100

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Төв аймгийн Сэргэлэн сумын Эрүүл мэндийн төвийн санхүүгийн тайланд аудит хийх явцад дараагийн аудитаар анхаарал татахуйц асуудал гараагүй ба аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилтийг давтан шалгах нь зүйтэй гэж үзлээ.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 371,299.5 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс 332.0 мянган төгрөгийн алдаа зөрчилд акт тогтоож, 18,000.9 мянган төгрөгийн зөрчилд албан шаардлага хүргүүлж, 352,966.6 мянган төгрөгийн өр төлбөр, шилэн данстай холбоотой зөвлөмж болон үндсэн хөрөнгийн данстай холбоотой зөвлөмж өгөв.

4.1 Төлбөрийн акт

1. Он дамжсан 3 байгууллагатай холбоотой 128.2 мянган төгрөгийн, 3 иргэнтэй холбоотой 203.8 мянган төгрөгийн нийт 332.0 мянган төгрөгийн авлагатай байна. Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8 "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах..." 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах", Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д "Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", санхүүгийн "үнэн зөв байдал", "эрх ба үүрэг" батламж мэдэгдлийг хангаагүй.

Шийдвэрлэсэн нь: Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1-д "албан шаардлага өгөхөд дараах нийтлэг үндэслэлийг харгалзана", 4.2.3.8-д "Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т заасан бусад нөхцөл байдал үүссэн" гэж заасныг үндэслэн акт тогтоов.

4.2 Албан шаардлага

1. Нэмэлт санхүүжилтийн дансанд Ковид 19-тэй холбоотой түргэвчилсэн оношлогоо шинжилгээний төлбөрийн орлого 12,890.4 мянган төгрөгийг бүртгэж тайлагнасан бөгөөд уг орлогыг нярав Оюунсүрэнгийн хувийн данснаас шилжүүлсэн байна. Энэ нь Сангийн сайдын 2012 оны 12 дугаар сарын 21-ний өдрийн 276 дугаар тушаалаар батлагдсан "Төсвийн байгууллагын мөнгөн кассын ажиллагааны журам"-ын 3 дугаар зүйлийн 3.10-д "Төсвийн байгууллагын дарга кассаас гадуур бэлэн мөнгөний орлого цуглуулах тохиолдолд энэхүү эрх бүхий ажилтныг томилно, .3.12-д "Эрх бүхий ажилтан хураасан орлогоо өөрийн байгууллагын бүртгэлийн дансанд ажлын 1 хоногт багтаан тушааж сар бүрийн эцэст зарагдсан тасалбарын бүртгэл болон орлого цуглуулсан баримтын (зарагдсан тасалбараас өөрт үлдэх хувь) тооцоог гаргаж, тайланг тушаана", Төсвийн тухай хуулийн 6 зүйлийн 6.3.2 д "санхүүгийн аливаа үйл ажиллагааг нягтлан бодох бүртгэлийн олон улсын болон үндэсний стандартын дагуу, цаг хугацаанд нь, үнэн зөв, илэрхийлэн бүртгэж, тайлагнах" гэсэн заалттай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1-д "албан шаардлага өгөхөд дараах нийтлэг үндэслэлийг харгалзана", 4.2.3.8-д "Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т заасан бусад нөхцөл байдал үүссэн" гэж заасныг үндэслэн албан шаардлага хүргүүлэв.

2. Байгууллага нь нийт 4 аж ахуйн нэгж байгууллагатай холбоотой 2,460.5 мянган төгрөгийн, 1 хувь хүнтэй холбоотой 2,650.0 мянган төгрөгийн худалдан авалт татварын цахим системд бүртгэгдээгүй, и-баримтаар нотлогдохгүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-д “Анхан шатны баримтын бүрдэлгүй, ажил гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно”, 20 дугаар зүйлийн 20.2.6-д “Эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах”, НӨАТ-ын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.3.2-т “Бараа ажил үйлчилгээг борлуулсан тухай бүр төлбөрийн баримтыг татвар төлөгчид олгоно”, 17.6-д “Албан татвар суутган төлөгч төлбөрийн баримтыг өөр дүнгээр олгосон, эсхүл төлбөрийн баримт олгохоос татгалзсан бол албан татвар төлөгч энэ талаар татварын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад, эсхүл харьяа татварын албанд нэн даруй мэдэгдэх үүрэгтэй”, санхүүгийн тайлангийн аудитын “эрх ба үүрэг”, “иж бүрэн байх” батламж мэдэгдлийг хангаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4.2.1-д “албан шаардлага өгөхөд дараах нийтлэг үндэслэлийг харгалзана”, 4.2.1.8-д “хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал ” гэж заасныг үндэслэн албан шаардлага хүргүүлэв.

4.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Үндсэн хөрөнгийн данстай холбоотой асуудал

1.1. Илрүүлэлт:

Үндсэн хөрөнгийн дансанд хуримтлагдсан элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн, үлдэгдэл өртөггүй, 56 ширхэг 73,947.0 мянган төгрөгийн хөрөнгө бүртгэлтэй байгаа нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 3.2-т “Илүүдэл эд хөрөнгө болон элэгдэл хорогдлын шимтгэлээр анхны үнийг нь нөхсөн, түүнчлэн нөхөөгүй боловч гэмтэж, засаж сэлбээд өөр зориулалтаар ашиглаж болох эд хөрөнгийн үнийг төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагатай зөвшилцөн тогтоох”, “Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолын 6.2-т “Төрийн өмчит хуулийн этгээдийн үндсэн хөрөнгийг дараах тохиолдолд Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын шийдвэрээр данснаас хасна”, 6.2.1-д “Элэгдлийн нийт хэмжээ, ашиглалтын хугацаагаараа балансын үнээ бүрэн нөхсөн бөгөөд цаашид зориулалтаар нь ашиглах боломжгүй болсон”, санхүүгийн тайлангийн аудитын “үнэлгээ ба хуваарилалт”, “иж бүрэн байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

1.2. Өгсөн зөвлөмж:

Анхны өртгөө хуримтлагдсан элэгдлээрээ бүрэн нөхсөн үндсэн хөрөнгийг холбогдох хууль, эрх зүйн актын хүрээнд санал гаргаж, эрх бүхий байгууллагуудад уламжлан шийдвэрлүүлэх

2. Өр төлбөрийн данстай холбоотой асуудал

2.1 Илрүүлэлт:

Он дамжсан 1 байгууллагатай холбоотой 1.5 мянган төгрөгийн, 3 иргэнтэй холбоотой 291.1 мянган төгрөгийн нийт 292.6 мянган төгрөгийн өр төлбөртэй байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8 “төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах...” 20.2.6-д “эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай

тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах", Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д "Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", санхүүгийн "үнэн зөв байдал", "эрх ба үүрэг" батламж мэдэгдлийг хангаагүй.

2.2 Өгсөн зөвлөмж:

Он дамжсан өр төлбөрийг төлж барагдуулах, бусдын өмнө хүлээх үүрэг хариуцлагыг биелүүлэх, өр төлбөр үүсгэхгүй төсвийг зохистой удирдах

3. **Шилэн данстай холбоотой асуудал**

3.1. Илрүүлэлт:

Төв аймгийн Сэргэлэн сумын Эрүүл мэндийн төв нь 2021 онд нийт 444,467.5 мянган төгрөгийн 36 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас 352,674.1 мянган төгрөгийн 23 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн зөрчилтэй байгаа нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3-т "тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх", Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам", санхүүгийн тайлангийн аудитын "иж бүрэн байх" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

3.2. Өгсөн зөвлөмж:

Шилэн дансны www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээлэх үүрэгтэй албан тушаалтан мэдээллийг тогтоосон хугацаанд нь тогтмол мэдээлэх, хуулийн хэрэгжилтийг бүрэн биелүүлж ажиллах зөвлөмж өгөв.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төв аймаг дахь Төрийн аудитын газар болон Гэрэлтэх бүртгэл Аудит ХХК-д 2022 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

д/д	Алдаа, зөрчлийн товч утга	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Санхүүгийн тайлангийн аудитын асуудал:											
1	Худалдан авалтыг И баримтаар баталгаажуулаагүй	1	5,110.5					1	5,110.5		
2	Няравын хувийн дансаар оношлогоо шийнжилгээний төлбөрийн орлого хураан авсан	1	12,890.4					1	12,890.4		
3	Он дамжсан авлагатай байна	1	332.0			1	332.0				
4	Он дамжсан өр төлбөртэй байна	1	292.6							1	292.6
5	Анхны өртгөө хуримтлагдсан элэгдлээрээ бүрэн нөхсөн хөрөнгө бүртгэлтэй байна	1	-							1	-
Дүн		5	18,625.5	-	-	1	332.0	2	18,000.9	2	292.6
Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал:											
1	Шилэн дансны цахим хуудсанд бүрэн мэдээлээгүй	1	352,674.0							1	352,674.0
Дүн		1	352,674.0	-	-	-	-	-	-	1	352,674.0
Нийт дүн		6	371,299.5	-	-	1	332.0	2	18,000.9	3	352,966.6